



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/У

Хажуу шинэ-Ус

Орон нутгийн хөгжлийн сангийн
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын “орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай” 1 дүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ түүний ач холбогдлыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх арга зүйн зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Нарийн бичиг: Хүнс. Жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: 1 дүгээр багийн Засаг дарга
4 дүгээр багийн Засаг дарга
Санхүү албаны дарга
Газрын даамал
Иргэний төлөөлөл

2. Иргэдэд төсвийн тухай хууль тогтоомжийг сурталчлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад олон нийтийн оролцоог жигд хангаж зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/03 дугаар тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



ТАРИУНАА